



ХЭНТИЙ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 06 сарын 10 өдөр

Дугаар A/39

Чингис хот

Өмч хамгаалах зөвлөлийг
шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын “Өмч хамгаалах зөвлөл”-ийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай .

Зөвлөлийн дарга: Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга

Нарийн бичгийн
дарга: Нутгийн захиргаа байгууллагын бодлого, тогтоол шийдвэрийн
хэрэгжилт хариуцсан ахлах мэргэжилтэн

Гишүүд:
Цэргийн штабын Тоо буртгэлийн Офицер
Санхүү, төрийн сангийн хэлтсийн Төсвийн орлого, хөрөнгө
оруулалтын санхүүжилт хариуцсан мэргэжилтэн
Нийгмийн бодлогын хэлтсийн Эрүүл мэнд, нийгмийн даатгал,
жендэрийн бодлого хариуцсан мэргэжилтэн

2. Аймгийн Засаг даргын Тамгын газрын “Өмч хамгаалах зөвлөл”-ийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Зөвлөлийн даргад үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан 2018 оны 10 дугаар сарын 08-ны A/45 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР

231030213